



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 5/39

Хэрлэн сум

Албан тушаал бууруулж,
ажил хавсруулан гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.2, 50 дугаар зүйлийн 50.2, 50.3, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсвийн шууд Захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарын аймгийн Засаг даргатай байгуулсан 2016 оны үр дүнгийн гэрээгээр хүлээсэн ажил үйлчилгээний хэрэгжилтийг үнэлсэн Боловсрол, соёл, урлагийн газрын дүгнэлтийг үндэслэн "D" буюу "Дутагдалтай" үнэлэгдсэн Мөрөн сумын цэцэрлэгийн эрхлэгч Ц.Баярмагнайгийн хөдөлмөрийн гэрээг 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн цуцлан албан тушаал бууруулж, тус цэцэрлэгийн багш Ч.Ариун-Ундрахыг мөн өдрөөс эхлэн цэцэрлэгийн эрхлэгч томилогдох өдрийг хүртэл эрхлэгчийн үүргийг хавсруулан гүйцэтгүүлсүгэй.

2. Эрхлэгчийн ажлыг хүлээлцэх комисс томилон ажиллуулахыг сумын Засаг дарга /Ц.Батцоож/-д даалгасугай.

3. Ц.Баярмагнайтай зохих хууль, журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусгах, эрхлэгчийн ажлыг хавсран гүйцэтгэх Ч.Ариун-Ундрахад үндсэн цалингаас нь 25 хувиар тооцон нэмэгдэл хөлс олгохыг цэцэрлэгийн нягтлан бодогч /Д.Шинэгэрэл/-д зөвшөөрсүгэй.

4. Ц.Баярмагнайг ажил хүлээлцсэн өдрөөс эхлэн ажлын байраар хангаж ажиллахыг цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг хавсран гүйцэтгэх Ч.Ариун-Ундрахад даалгасугай.

5. Эрхлэгчийн ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

01 881